

"ХИШИГ-УУЛ" ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

"Хишиг-Уул" ХК ("Компани" гэх)-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө, 3-р хороо, Улсын Их Дэлгүүрийн 7 давхрын уулзалтын өрөөнд 14:40 минутад эхлэв.

Хурал даргалагч Я.Нэргүй: Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын дагуу Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж байна. Тооллогын комиссоос ирцийн мэдээллийг өгнө үү.

Тооллогын комисс: Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2024 оны 4 сарын 12-ны тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн нийт гаргасан 868,252 ширхэг энгийн хувьцаанаас 30,29%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Я.Нэргүй, 16,39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Ц.Роза, 1,5%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн, 0,65%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав нар биеэр, 4,27%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Г.Байгалмааг итгэмжлэлийн үндсэн дээр Я.Нэргүй төлөөлж оролцож байгаа нь энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 53,1%-г эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаа болохыг хурал оролцогчдод мэдэгдэж байна. Компанийн 34 хувийг эзэмшдэг нэг хувьцаа хувьцаа эзэмшигч буюу Нийслэлийн Өмчийн Харилцааны Газраас энэ удаагийн хуралд оролцоогүй болохыг дурдаж байна.

Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 53,1%-ийн ирцтэйгээр оролцож байгаа тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр ирцтэй эхэлж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулж, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлав. Хэлэлцэх асуудлын жагсаалт:

Нэг. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2024 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;

Нэгдүгээр асуудал. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Хурал даргалагч Я.Нэргүй Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Я.Нэргүй: Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав. Манай компани нь 2020 болон 2021 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хүнд үеийг улсын эдийн засгийн хөнгөлөлт, Засгийн Газраас хэрэгжүүлсэн нийслэлийн өмчийн оролцоотой учраас ААНОАТ, НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, цахилгаан, дулааны зардлуудыг хөнгөлсөн хөнгөлөлтүүдэд нэгэнд нь ч хамрагдаагүй, маш хүнд үеийг хамт олны хүч хөдөлмөр болон захирлууд, нягтлангууд бид цалингийн зээл авч байж даван туулсан. 2020 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй 250 сая төгрөгийн зээл авснаар хүнсний төвийн

барааны зузаатгалыг хийгдэж, ажилчдын цалинг олгох, бусад зардлуудыг цаг хугацаандаа гаргасан бөгөөд энэ зээл үр дүнтэй хэрэгжиж, зээлийн төлөлт нь 3 сард дууссан. Энэ нь компанийг хаалгаа барихаас сэргийлж чадсан. Бид өөрсдийн хувийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалж зээл авч байсан. Цар тахлын дараах 2023 оны борлуулалтын орлого 1,5 тэрбум, татварын дараах цэвэр ашиг 9 сая 17 мянга болсон.

С.Мягмарсүрэн: 2023 онд хэдэн төгрөгийн түрээсийн орлого олсон бэ? Супермаркетаас хэдий хэмжээний орлого олсон бэ? Хэдэн м.кв-г түрээслүүлсэн бэ? Цаасан дээр бичсэн юмыг уншихаар бидний нойр хүрч байна шүү дээ. Цаасан бичсэн юмыг унших ямар ч шаардлагагүй.

Я.Нэргүй: Борлуулалтын зардал нь 1 тэрбум 247 сая төгрөг болсон нь ААНОАТ, НӨАТ, НДШ нийлээд 43 хувь, урсгал зардал, бензин, хүнсний өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой. 2019-2022 онуудад компанийн гол үйл ажиллагаа явуулдаг “Хэрлэн” худалдааны төвийн дээвэр эвдэрсэнтэй холбоотойгоор нүхтэй хавтан, хана тааз, даацын ханыг даган урсаж түрээслэгч нарын эд хөрөнгөд хохирол учирч, үүнийг Компанийн зүгээс барагдуулж байсан. 2023 оны 5 сараас 10 сарын хооронд барилгын ажлын норматив тооцоолол, тухайн үеийн зах зээлийн ханшаар 360,6 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэх байсан ажлыг аж ахуйн аргаар 124 сая төгрөгөөр зардал гарган, уг төсвөөс 2,9 дахин хямд өртгөөр дээврийн засварын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Дээвэр бүтэн болсноор энэ онд гэмтэж норсон хана, тааз, нөхөн сэргээх ажил, дотор заслын ажлууд хүлээгдэж байна. Энэ ажлын байрын нөхцөлийг сайжруулах шаардлагатай, төсөв тооцоог хараахан гаргаагүй байна. Тус ажлыг УИХ-ын сонгуулийн өмнө хийх тулгамдсан шаардлага байгаа тул үүнийг нийслэлийн зүгээс тусламж үзүүлэх боломжтой эсэхийг тодруулах шаардлагатай.

С.Мягмарсүрэн: 2023 онд хэдэн төгрөгийн түрээсийн орлого олсон бэ? Төрийн банканд яг хэдэн төгрөгөөр түрээсэлдэг юм бэ?

Я.Нэргүй: Сар, сараар жил болгоноор нь мэдээллийг бэлдэн гаргасан байгаа. Тус мэдээллийг өчигдөр татварт тайлагнаснаар Авлигатай тэмцэх газарт хүлээлгээд өгчихсөн байгаа, яг одоо бид тооцооллыг шууд хэлэх боломжгүй байна. Холбогдох материалыг араас хүргүүлье.

С.Мягмарсүрэн: Тэгэхээр хурал гэдэг утгагүй болж байна. Компанийн эрх барих дээд байгууллага учраас энэ талаарх мэдээллийг асууж байна. Орлогын тайлан дээр түрээсийн орлогоо тусгаагүй байна. Энэ хурлаар бүх материал бэлэн байх шаардлагатай.

Я.Нэргүй: Бид хуралд бэлдээд СЗХ, МХБ-д өгсөн материалынхаа хүрээнд хурлаа хийж байна.

С.Мягмарсүрэн: Юу гэсэн үг вэ? Би компанийн түрээсийн орлого асууж байна. Таны ингэж хэлж байгаа нь бид СЗХ, МХБ-тэй хамтарч ажилладаг, жижиг хувьцаа эзэмшигчдээс түрээсийн орлогоо хэлэхгүй нуучихдаг юмаа гэсэн ойлголт авч байна.

Ц.Роза: Нуусан зүйл байхгүй. Багануурт очихоороо танруу материалуудаа явуулъя.

С.Мягмарсүрэн: Одоо амаар хэлэх хэрэгтэй. Яагаад мэддэггүй юм бэ?

Я.Нэргүй: Батлагдсан тайлан дээр байгаа, албаны журмаараа тайландаа тайлагнасан байгаа. Дараа нь та бүгдэд материалыг өгье. Бид хурлын дэгийн дагуу СЗХ, МХБ-д өгсөн зарын дагуу хэлэлцэх асуудлын хүрэн дэх асуудлаа ярилцана.

Ажиглагч, ТУЗ-ийн гишүүн Д.Сэржамц: Зарчмын хувьд энэ саналуудыг протоколд тэмдэглээд, мэдээллийг өгөх байх. Үүн дээр маргах шаардлага байхгүй байна.

С.Мягмарсүрэн: Сэржамц таныг хуралд ирсэнд баяртай байна. Та ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хөндлөнгөөс хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөөд сууж байгаа хүн юм. Та бас энэ түрээсийн орлогын талаарх мэдээллийг мэдэж байх шаардлагатай.

Д.Сэржамц: Яг одоо бэлэн тоо байхгүй байна, задаргааг нь гаргаад өгөх боломжтой.

С.Мягмарсүрэн: Та хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж юу хийж ажиллаж байгаа вэ, цаашид яаж ажиллах вэ, хэдэн төгрөгийн цалин авдаг вэ?

Д.Сэржамц: Улиралд цалингийн доод хэмжээгээр нэг авдаг. Хараат бус гишүүн бол бие даагаад шинжилгээ хийх, ТУЗ-н хуралд оролцож байгаа асуудалд анхаардаг. Ялангуяа ногдол ашгийн хувьд 9 сая төгрөгийн ашигтай байгаа учраас ер нь байдал нилээн уначихсан хэцүү болсон компани авсан. Зардлаа нөхөх гэж явсаар дээвэр нь эвдрээд, зээл авч чадахгүй байгаа.

С.Мягмарсүрэн: ТУЗ хэдэн удаа хуралдсан бэ?

Д.Сэржамц: 2023 онд ТУЗ 3 удаа хуралдсан.

С.Мягмарсүрэн: Та хувьцаа эзэмшигчдийг төлөөлж сууж байгаа. Түрээсийн орлого бүртгээгүй байгаа дээр ямар байр суурьтай байна вэ?

Д.Сэржамц: Түрээсийн орлого бүртгэгдээд, тайлагнаад явж байгаа.

Ц.Роза: Та бүхэнд хэлэлцэх асуудалтай холбоотой санал байвал саналаа хэлээд, асуулт хариултын зарчмаар явъя.

С.Мягмарсүрэн: Та хэд ийм хагас тайлан гаргачхаад, бид нараар хэлэлцүүлнэ гээд сууж байгаа нь ичгэвтэр байна. Энэ тайланд чинь түрээсийн орлогын мэдээлэл байхгүй байна.

Ажиглагч н.Тэмүүжин: Би саналын эрхгүй, ажиглагчаар энэ хуралд оролцож байна. Би өөрөө Нийслэлийн өмчийн харилцааны газрын Дотоод хэлтэс, аудитын хэлтсийн дарга Тэмүүжин гэдэг хүн байна. Өнгөрсөн долоо хоногт энэ байгууллагад урьдчилсан байдлаар хяналт шалгалтын байдлаар ажлын хэсгийг ахлаж очсон. Энэ ТУЗ-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал маань бүгдийг нь монгол хэлээр биччихсэн, мангар хүн ч ойлгохоор гэдэг шиг ийм ийм хэлэлцэнэ гээд оруулчихсан. Танай байгууллагын дотоод гүнзгий асуудалд би оролцох эрхтэй хүн биш. Гэхдээ хууль хяналтын байгууллага дээр талууд өөрсдөө санал, гомдлоо гаргаад, харьяа чиглэлийн хууль хяналтын байгууллагууд нь хяналт шалгалтаа хийгээд явж байгаа. Манай нийслэлийн зүгээс бид нар өөрсдийгөө хяналт шалгалтыг явуулаад тайлан бэлтгэгдэх ажлууд явж байгаа. Тэгэхээр энэ дээр маргаад байх шаардлага байна уу? Хуулийн байгууллага нь гаргаад ирэх нь тодорхой, манайхаас хяналт шалгалтын ажил явсан тайланг хугацаатай үүрэг даалгаврын дагуу хотын дарга дээр танилцуулагдаад явна. Энэний дараа компанийн хувьцаа эзэмшигчид та бүхэн өөрсдөө хотын дарга та бүхнийг дугуй ширээний ярилцлагад дуудах байх. Тэр асуудал дээр та бүхний хууль хяналтын байгууллагад гаргасан санал гомдол манай зүгээс хийж байгаа хяналт шалгалтын асуудал, та бүхний өөрсдийн гомдлын дагуу шүүхээс гарсан шийдвэрүүд байсан. Тэр асуудлыг нарийн хэлэлцээд нэг талдаа шийдвэрүүд гарах байхаа. Энэд дуугаа өндөрсгөөд, хоорондоо хэрэлдлээ гээд нэг ширхэг тоо хариулж чадахгүй байна. Монгол улс хуультай, тусгаар тогтносон улс. Хэрэгцээ шаардлагатай хуулийн байгууллага нь хяналтаа хийнэ. Тэр тал дээр нь хоорондоо эв зүйтэй, хурлаа бужигнахгүй явъя.

С.Нэргүй: Дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Гуравдугаар асуудал: Компанийн 2024 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

С.Мягмарсүрэн: 2024 онд хэдэн төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллах, үүнээс хэдэн төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байгаа вэ? Олон зүйл ярих шаардлагагүй байхаа.

Я.Нэргүй: Борлуулалтын орлого 2024 онд 1 тэрбум 750 сая төгрөг байхаар тооцоо гарсан. Цэвэр ашгийн хувьд шууд тодорхойлох боломжгүй, тухайн үеийн зах зээл, бизнесийн орчноос шууд хамаарна.

Ц.Роза: Хотын төвд байсан бол бас нэг өөр асуудал. Харин алслагдсан, зах зээл муутай, хүн ам цөөтэй, өрсөлдөгч ихтэй учраас шууд тодорхойлоход хүндрэлтэй. Мэргэжлийн хяналтын торгууль, төлөөс, алданги гээд маш их дарамтад компани ажилладаг. Бид маш олон эрсдэл, дэмжлэг тусламжгүй ажилласаар ирсэн.

Я.Нэргүй: 2024 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.

Хүнсний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний борлуулалтыг хэрэглэгчдэд ойртуулж нийт борлуулалтын орлогыг 1 тэрбум 750 сая төгрөг байхаар тооцоолсон. Гол дээврийн засвар дууссанаар 1,900 м.кв талбайд дотор засварын ажил хийгдэх нэн тэргүүний шаардлага байгаа. Энэ засварын ажилд түрээсийн орлогоос дийлэнх нь орж байгаа. 2023 оны зах зээлийн ханшаар 360 сая төгрөгийн төсвөөр хийх ажлыг 124 саяар хийсэн.

С.Мягмарсүрэн: Хэр чанартай хийсэн вэ?

Я.Нэргүй: Чанартай. Би өөрөө Эрээн явж материалуудаа авсан. 3,100м.кв-г 124 саяар тооцоход 1м.кв-н үнэ гарч ирнэ.

С.Мягмарсүрэн: Жил болгон дээврийн асуудал гардаг. 25,000м.кв газрыг Улаанбаатар хивс 800 саяар мембран дээврээр зассан байсан. Таны хийсэн нь 40-д мянга гэхээр үнэтэйд орохоор байна. Хар хаммер урсгачихсан юм шиг байна.

С.Нэргүй: Хар лава биш, би барилгын инженер хүн байсан бол хэрлэн худалдааны төв аль эрт нураад унах байсан.

С.Пүрэвжав: Дээвэр дээр хавтан хоорондын зай үүссэн байсан. Тэрийг бөглөсөн байналээ.

С.Нэргүй: Хавтан хооронд зай байхгүй. Агшилт суналтын шоо гэж байдаг, тэр хамааралгүй зүйл.

С.Пүрэвжав: Хурал гэхэд хэцүү байна. Ирж байгаа хүмүүс нь гаднаас гэвэл бид хоёр, бусад нь доторх хүмүүс байна.

Ц.Роза: Ажлаа тайлбарлах гэж бид ирсэн. ТУЗ-н хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, дүгнэлтийн дагуу танилцуулж байна. Бид хууль зүйн хувьд шалгагдаад явж байгаа.

Дөрөвдүгээр асуудал: ТУЗ-н гишүүдийг томилох.

Хурлын дарга Я.Нэргүй: ТУЗ-ийн 7 гишүүнийг улируулан сонгож, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Энххорлоо нас барсан тул түүнийг чөлөөлж, Д.Энхбаярыг Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэх, мөн НИТХ-с Нийслэлийн Өмчийн Харилцааны Газраас томилогдсон Т.Отгонболд гишүүнийг чөлөөлж, түүний оронд Нийслэлийн Өмчийн Харилцааны Газрын Ахлах мэргэжилтэн С.Сэржжаргалыг томилсон тул Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэхээр ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд санал дэвшүүлсэн.

Ц.Роза: Д.Энхбаяр гишүүнийг хаанаас санал болгосон бэ?

Я.Нэргүй: Манайхаас санал болгосон байгаа, хувийн хэвшлийн байгууллагын хүн байгаа. Бүх шаардлагаа хангаж орж ирсэн байгаа.

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээний хүрээнд ТУЗ-н гишүүдийг сонгох эрхтэй байх тул ТУЗ-н хурлаас дэвшүүлсэн нэр дэвшигч гишүүдийг ТУЗ-н гишүүдээр томилох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжин томилов.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хуралд оролцсон ТУЗ-ийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн 2024 оны Бизнес төлөвлөгөөг сонсож, цаашид Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллахыг даалгасугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. С.Сэржжаргал
4. С.Даваасүрэн
5. Н.Сүлд-Оргил
6. Д.Энхбаяр

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор
2. Д.Сэржамц
3. Ж.Ганболд
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч С.Батчимэг, А.Солонго нарт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулж дууссаны дараагаар Хурал даргалагч Я.Нэргүй хурал хаасныг мэдэгдэв. Хурал 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15:30 цагт хаав.

ХУРЛЫН ДАРГА:



Я.НЭРГҮЙ